



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/100/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Ауд. 02.25 № 115

-ны № -г

Аудитын санал дүгнэлт

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Г.БАЯРБАТ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, өмчлөгч гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Хайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг үйлдлийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан үндсэн зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын үйлдлийн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай үндэстэй зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хяналт үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэстэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд зангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>49,338,195.33</u>	<u>72,869,933.10</u>
33	АВЛАГА	448,790.46	6,630,301.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	363,670.46	6,545,181.00
335	Бусад авлага	85,120.00	85,120.00
3351	Байгууллагаас авах авлага	85,120.00	85,120.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,889,404.87	66,239,632.10
351	Түүхий эд материал	763,800.00	10,506,840.00
35130	Эм боох материал	763,800.00	10,506,840.00
354	Хангамжийн материал	46,685,604.87	53,527,792.10
35410	Бичиг хэргийн материал	10,228,100.00	13,292,954.10
35420	Аж ахуйн материал	22,906,022.27	22,554,245.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	2,673,909.00	5,249,545.00
35450	Барилгын засварын материал	9,811,655.00	8,100,160.00
35460	Хүнсний материал	1,065,918.60	4,330,888.00
35470	Бусад хангамжийн материал		
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	1,440,000.00	2,205,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,752,899,314.21</u>	<u>2,728,749,094.79</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,752,899,314.21	2,728,749,094.79
391	Газар		
392	Биет хөрөнгө	2,690,543,314.21	2,666,393,094.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,814,126,896.08	2,814,126,896.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	(249,460,777.97)	(276,041,847.65)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	287,667,499.46	279,988,711.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(245,490,566.65)	(236,304,466.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	155,981,195.28	150,890,489.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(104,791,287.99)	(99,993,921.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,800,804.00	43,248,519.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	(36,838,639.04)	(37,069,477.46)
39217	Ном	27,548,191.04	27,548,191.04
393	Биет бус хөрөнгө	62,356,000.00	62,356,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	62,356,000.00	62,356,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,802,237,509.54</u>	<u>2,801,619,027.89</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,802,237,509.54</u>	<u>2,801,619,027.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,802,237,509.54	2,801,619,027.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	826,111,847.24	826,111,847.24
51101	Өмч: - төрийн	826,111,847.24	826,111,847.24
512	Хуримтлагдсан үр дүн	(206,008,661.73)	(206,627,143.38)
51210	Өмнөх үеийн үр дүн	(206,008,661.73)	(206,008,661.73)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(618,481.65)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,182,134,324.03	2,182,134,324.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,802,237,509.54</u>	<u>2,801,619,027.89</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,076,215,480.00	1,122,209,576.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,815,680.00	7,030,122.20
120	Нийтлэг татварын бус орлого	76,815,680.00	7,030,122.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,815,680.00	7,030,122.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,815,680.00	7,030,122.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	999,399,800.00	1,115,179,454.55
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	943,816,600.00	1,056,743,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	943,816,600.00	1,056,743,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,886,054.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,886,054.55
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,583,200.00	49,549,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,583,200.00	49,549,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,164,444,089.01	1,122,828,058.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,164,444,089.01	1,122,828,058.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,118,286,960.01	1,090,791,335.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	762,886,661.00	855,993,071.69
210101	Үндсэн цалин	571,765,250.00	675,153,738.69
210102	Нэмэгдэл	90,179,166.00	112,946,714.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	100,942,245.00	67,892,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,768,874.77	102,691,565.54
210201	Тэтгэврийн даатгал	66,960,701.20	74,057,999.35
210202	Тэтгэмжийн даатгал	7,583,982.49	7,305,945.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,050,667.86	5,838,035.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,470,319.92	1,408,143.71
210205	Эрүүл мэндийн даатгал	14,703,203.30	14,081,441.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,628,929.00	42,866,654.00
210301	Гэрэл, цахилгаан	11,046,600.00	11,634,990.00
210302	Түлш, халаалт	40,832,329.00	30,766,664.00
210303	Цэвэр, бохир ус	750,000.00	465,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,136,000.00	21,368,457.27
210401	Бичиг хэрэг	2,796,000.00	2,596,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	7,762,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,200.00	857,000.00
210404	Ном, хэвлэл	259,300.00	388,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	262,400.00	726,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,618,100.00	7,701,547.27
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	-	1,335,000.00
2105	Нормативт зардал	36,543,225.00	25,310,150.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,650.00	1,362,000.00
210502	Хоол, хүнс	35,555,575.00	22,404,150.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	868,000.00	1,544,000.00

Архангай аймгийн Хайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,559,360.00	1,845,495.00
210604	Урсгал засвар	4,559,360.00	1,845,495.00
2107	Томилолт, зочны зардал	228,000.00	-
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	228,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,074,600.00	1,618,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,074,600.00	818,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,461,310.24	39,097,441.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,037,458.00	5,055,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,423,852.24	34,041,591.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,157,129.00	32,036,722.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,518,228.00	27,131,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,292,450.00	25,537,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,225,778.00	1,593,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,638,901.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,638,901.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,905,622.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,905,622.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(88,228,609.01)</u>	<u>(618,481.65)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(88,228,609.01)</u>	<u>(618,481.65)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	826,111,847.24	2,182,134,324.03	(110,407,933.27)	2,897,838,238.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	826,111,847.24	2,182,134,324.03	(110,407,933.27)	2,897,838,238.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(95,600,728.46)	(95,600,728.46)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	826,111,847.24	2,182,134,324.03	(206,008,661.73)	2,802,237,509.54
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	826,111,847.24	2,182,134,324.03	(206,008,661.73)	2,802,237,509.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	826,111,847.24	2,182,134,324.03	(206,008,661.73)	2,802,237,509.54
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(618,481.65)	(618,481.65)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	826,111,847.24	2,182,134,324.03	(206,627,143.38)	2,801,619,027.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	999,399,800.00	1,115,179,454.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	999,399,800.00	1,115,179,454.55
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	943,816,600.00	1,056,743,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	943,816,600.00	1,056,743,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,886,054.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,886,054.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,583,200.00	49,549,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,583,200.00	49,549,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	997,649,704.00	1,109,929,454.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	997,649,704.00	1,109,929,454.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	949,621,525.00	1,077,037,431.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763,734,876.00	853,163,799.69
210101	Үндсэн цалин	571,765,250.00	617,342,800.00
210102	Нэмэгдэл	90,958,201.00	163,710,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	101,011,425.00	72,110,499.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,180,476.00	111,712,348.08
210201	Тэтгэврийн даатгал	57,617,250.00	81,766,439.87
210202	Тэтгэмжийн даатгал	6,240,926.00	7,826,633.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,996,684.00	5,923,683.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,344,367.00	1,454,700.66
210205	Эрүүл мэндийн даатгал	12,981,249.00	14,740,891.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,763,200.00	49,549,700.00
210301	Гэрэл, цахилгаан	11,046,600.00	11,993,100.00
210302	Түлш, халаалт	40,966,600.00	36,866,600.00
210303	Цэвэр, бохир ус	750,000.00	690,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,108,300.00	13,180,209.10
210401	Бичиг хэрэг	525,700.00	2,218,454.55
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	6,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,475,200.00	863,100.00
210404	Ном, хэвлэл	345,600.00	388,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	262,400.00	900,354.55
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,499,400.00	2,809,400.00
2105	Нормативт зардал	31,197,515.00	37,271,380.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	271,100.00	11,002,290.00
210502	Хоол, хүнс	29,217,715.00	24,639,290.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,708,700.00	1,629,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,820,000.00	-
210604	Урсгал засвар	3,820,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	228,000.00	-
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	228,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,074,600.00	2,223,500.00

Архангай аймгийн Хайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,074,600.00	1,423,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,514,558.00	9,936,495.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,514,558.00	9,936,495.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,028,179.00	32,892,022.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,389,278.00	27,986,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,148,500.00	26,437,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,240,778.00	1,548,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,638,901.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,638,901.00	-
213404	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,905,622.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,905,622.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,750,096.00</u>	<u>5,250,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	5,250,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,250,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,250,000.00
223001	Бусад хөрөнгө	-	5,250,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(5,250,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,750,096.00	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,106,293,400.00	1,101,387,777.32	4,905,622.68	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,106,293,400.00	1,101,387,777.32	4,905,622.68	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,076,693,400.00	1,073,401,377.32	3,292,022.68	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853,163,800.00	853,163,799.69	0.31	100
210101	Үндсэн цалин	617,342,800.00	617,342,800.00	-	100
210102	Нэмэгдэл	163,710,500.00	163,710,500.00	-	100
210104	Урамшуулал	72,110,500.00	72,110,499.69	0.31	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,840,200.00	111,712,348.08	3,127,851.92	97.3
210201	Тэтгэврийн даатгал	83,304,800.00	81,766,439.87	1,538,360.13	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	7,883,900.00	7,826,633.13	57,266.87	99.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,307,100.00	5,923,683.00	383,417.00	93.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,576,700.00	1,454,700.66	121,999.34	92.3
210205	Эрүүл мэндийн даатгал	15,767,700.00	14,740,891.42	1,026,808.58	93.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,549,700.00	49,549,700.00	-	100
210301	Гэрэл, цахилгаан	11,993,100.00	11,993,100.00	-	100
210302	Түлш, халаалт	36,866,600.00	36,866,600.00	-	100
210303	Цэвэр, бохир ус	690,000.00	690,000.00	-	100
210304	Байрны түрээс			-	
2104	Хангамж, бараа материалын зардал	12,302,100.00	12,294,154.55	7,945.45	99.9
210401	Бичиг хэрэг	1,837,400.00	1,837,400.00	-	100
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	6,000,000.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	866,900.00	863,100.00	3,800.00	99.6
210404	Ном, хэвлэл	388,900.00	388,900.00	-	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	398,900.00	395,354.55	3,545.45	99.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,810,000.00	2,809,400.00	600	100
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал			-	
2105	Нормативт зардал	40,751,800.00	40,721,380.00	30,420.00	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,456,300.00	14,452,290.00	4,010.00	100
210502	Хоол, хүнс	24,660,400.00	24,639,290.00	21,110.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,635,100.00	1,629,800.00	5,300.00	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,223,700.00	2,223,500.00	200	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,423,700.00	1,423,500.00	200	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	-	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,862,100.00	3,736,495.00	125,605.00	96.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,862,100.00	3,736,495.00	125,605.00	96.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,600,000.00	27,986,400.00	1,613,600.00	94.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,600,000.00	27,986,400.00	1,613,600.00	94.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,050,000.00	26,437,500.00	1,612,500.00	94.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,550,000.00	1,548,900.00	1,100.00	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,106,293,400.00	1,101,387,777.32	4,905,622.68	99.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,056,743,700.00	1,051,838,077.32	4,905,622.68	99.5
131001	Улсын төсвөөс санхүүжих			-	

Архангай аймгийн Хайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн тайлан

131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих			-	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,056,743,700.00	1,051,838,077.32	4,905,622.68	99.5
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих			-	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,549,700.00	49,549,700.00	-	100
132001	Орон нутгийн төсвөөс	49,549,700.00	49,549,700.00	-	100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
610002	Төсвөөс гадуур байгууллага			-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	73	73	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	42	42	-	100
620003	Үйлчлэх ажилтан	30	30	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	963,000.00	8,886,054.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	963,000.00	7,086,054.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	963,000.00	7,086,054.55
2104	Хангамж, бараа материалын зардал	-	886,054.55
210401	Бичиг хэрэг	-	381,054.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	505,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	963,000.00	6,200,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	963,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,800,000.00
223001	Бусад хөрөнгө	-	1,800,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	963,000.00	8,886,054.55
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	963,000.00	8,886,054.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	963,000.00	8,886,054.55
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, Захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Хайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Шилдэг технологид суурилсан багш сурагчдаа хөгжүүлсэн “Бүс нутгийн тэргүүлэх сургууль” болох”-д оршино гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургууль хүний хөгжлийн төв байх
- Ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлж хууль дүрмийг хэрэгжүүлэх
- Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороосон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээл сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөрийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү аж ахуйн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хяналт шалгалт хийж ажилласан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Батлагдсан төсөв”-ийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,106.3 сая төгрөгийн 1 хувь буюу 11.06 сая төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь элэгдлийн зардал болон хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.4	6.6	6.2
Бараа материал	48.9	66.2	17.4
Үндсэн хөрөнгө	2,752.9	2,728.7	(24.2)
Нийт хөрөнгө	2,802.2	2,801.6	(0.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,802.2	2,801.6	(0.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,802.2	2,801.6	(0.6)

- Авлагын дансны үлдэгдэл 6.2 сая төгрөгөөр өссөн нь ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг сар дамжуулж төлбөр тооцоо хийхдээ тооцооллоо алдаж дахин төлбөр тооцоог барагдуулснаар авлага үүсжээ.
- Бараа материалын данс нь 48.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 112.9 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 2.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд 97.9 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 66.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Үндсэн хөрөнгө данс 2,752.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байгаа ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 5.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан

4.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 21.2 сая төгрөгийн хөрөнгө акталж хассан байна. Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 636.6 сая төгрөг байснаас тайлант хугацааны элэгдэл 34.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, үндсэн хөрөнгийн акталсантай холбоотойгоор данснаас хассан элэгдэл 21.2 төгрөгөөр тус тус хасагдаж 2,728.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 0.6 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал, хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	943.8	1,056.7	112.9
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	55.6	49.5	(6.0)
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8.9	8.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76.8	7.0	(69.8)
Үйл ажиллагааны орлого	1,076.2	1,122.2	46.0
Цалин, шимтгэлийн зардал	859.7	958.7	99.1
Бараа үйлчилгээний зардал	106.1	91.4	(14.7)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1.1	1.6	0.5
Бараа үйлчилгээний бусад зардал	151.5	39.1	(112.4)
Урсгал шилжүүлэг	46.2	32.0	(14.1)
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-	-
Үйл ажиллагааны зардал	1,164.4	1,122.8	(41.6)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(88.2)	(0.6)	87.6

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого өмнөх оноос 112.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсөв нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,106.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

.Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 1,106.3 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,106.3 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр тусгай зориулалтын сангаас 1,051.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 49.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,096.5 сая төгрөгийг зарцуулж 4.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,096.5 сая төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 8.9 сая мянган төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээр 8,9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авч бичиг хэргийн материалд 0.4 сая, хог хаягдал зайлуулахад 0.5 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 6.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2021 онд тус байгууллага нь “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, хичээл сургалтын үйл ажиллагааны явцад халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбоотой сургууль орчмын бүс, сургалтын байр анги танхимд 2 цаг тутам цэвэрлэгээ, 10 хоногт 2 удаа ариутгал хийж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90 хувь байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан нийт 1,106.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,096.5 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.6 хувь байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллээс 138 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байх тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

1. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтын хүрээнд төсвийн хасагдах тохируулга хийснээр тус байгууллага нь 108.7 сая төгрөгийг зарцуулахаас гүйцэтгэлээр 108.5 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тогтоолын хүрээнд 10.8 сая төгрөгийн хэмнэлт гаргахаас 0.1 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, 10.7 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй 10.7 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

2. Тус байгууллага нь тогтмол зардалд /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус/ 49.5 сая төгрөг батлуулж, гүйцэтгэлээр 49.5 сая төгрөгийн зардал гаргаж, 9.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй ажилласан байна

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8-д заасан тогтмол зардалд 20-ис доошгүй хувийн хэмнэлт гаргах гэсэн заалтыг мөрдөөгүйд албан шаардлага хүргүүлэв

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 51.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, шилэн дансны хугацаа хоцроосны зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 51.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснөөс шилэн данстай холбоотой 1 албан шаардлага хэрэгжээгүй бусад зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг анхаарч үзэх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 49.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.8 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1 алдаанд хариуцлага тооцох албан шаардлага, 27.2 сая төгрөгийн алдаанд зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Цалингийн зардлаас НДШ, ХХОАТ, Бусад өглөгүүдэд 13.4 сая төгрөгийн бичилт хийсэн.
- НДШ-ийн зардлаас 0.5 сая төгрөгийг өглөгт бүртгэсэн
- Гэрэл цахилгааны төлбөр 7.9 сая төгрөгийн ЭБЦТС-ийн тооцооны дансыг түлш халаалтын тооцооны данстай хольж бүртгэсэн

4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд тооцооллын алдаа гаргаж 6.6 сая төгрөгийн авлага үүсгэж барагдуулаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 39 дүгээр зүйлийн 39.4.2-т “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хайрхан сумын ерөнхий боловсролын сургууль	4	28.4	3	21.8	0	0	1	6.6	0	0
	Дүн	4	28.4	3	21.8	0	0	1	6.6	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Хайрхан сумын ерөнхий боловсролын сургууль	2	20.6	0	0	0	0	2	20.6	0	0
	Дүн	2	20.6	0	0	0	0	2	20.6	0	0
	Нийт дүн	7	49.0	3	21.8	0	0	3	27.2	0	0